



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА Д.МӨРӨН ТАНАА

МОНГОЛ УЛСЫН
ГАДААД ХАРИЛЦААНЫ ЯАМ

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 7а, Утас: 26 21 35,
Факс: (976-11) 32 21 27, E-mail: info@mfa.gov.mn,
http://www.mfa.gov.mn

2018. 01. 24 № 09/532
танай _____-ны № _____-т

Хэлэлцээр хүчин төгөлдөр
мөрдөгдөж эхлэх тухай


"Дипломат болон албан паспорт эзэмшигчдийг визийн шаардлагаас чөлөөлөх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Мальта Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр"-т 2016 оны 7 дугаар сарын 14-ны өдөр гарын үсэг зурсан.

Уг хэлэлцээр нь түүний 11 дүгээр зүйлд "Хэлэлцэн тохиролцогч талууд түүнийг хүчин төгөлдөр болгох талаар дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа дипломат шугамаар харилцан мэдэгдсэн сүүлчийн бичгэн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дараа хүчин төгөлдөр болно" гэж заасны дагуу 2018 оны 2 дугаар сарын 8-ны өдрөөс хүчин төгөлдөр болохыг үүгээр мэдэгдэв.

Холбогдох байгууллагадаа уламжлах чиглэлээр ажиллана уу.

Хавсралт: Хэлэлцээрийн хуулбарыг хүргүүлэв.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Д.ДАВААСҮРЭН



С. Дорайгалант

Холбогдох байгууллагад
уламжлах, эрх зүйн
хүргүүлэх, яамдын
мөхөх ажилар
2/8

Д.Мөрөн Танаа

Холбогдох байгууллагад
уламжлах, эрх зүйн
хүргүүлэх, яамдын
мөхөх ажилар
2018.01.26
Т/26



**ДИПЛОМАТ БОЛОН АЛБАН ПАСПОРТ ЭЗЭМШИГЧДИЙГ
ВИЗИЙН ШААРДЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
БҮГД НАЙРАМДАХ МАЛЬТА УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Мальта Улсын Засгийн газар, цаашид "Хэлэлцэн тохиролцогч Талууд" гэх,

Хоёр улсын хоорондын найрсаг харилцааг гүнзгийрүүлэн хөгжүүлэхийг эрмэлзэн,

Хэлэлцэн тохиролцогч Талуудын дипломат болон албан паспорт эзэмшигч иргэдийг хоёр улсын хооронд харилцан зорчихыг хөхиүлэн дэмжиж, уг нөхцөлийг хөнгөвчлөхийг зорьж,

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч иргэд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт нэвтрэн орсноос хойш гуч (30)-аас дээшгүй хоног визгүйгээр нэвтрэн орох, гарах, дамжин өнгөрөх болон зорчих эрхтэй.

2 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч иргэд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт гуч (30)-ээс дээш хоногийн хугацаанд зорчих тохиолдолд урьдчилан виз авах үүрэгтэй.

3 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт байгаа Дипломат төлөөлөгчийн газар, Консулын төлөөлөгчийн газар болон Олон улсын байгууллагад ажиллахаар томилогдсон Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч иргэд болон тэдгээрийн хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч гэр бүлийн гишүүд хүлээн авагч улсад ирэхээсээ өмнө зөвшөөрөл (аккредитаци)-ийн виз авах үүргээс энэхүү хэлэлцээрээр чөлөөлөгдөхгүй.

4 дүгээр зүйл

Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч иргэд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын олон улсын зорчигчдод нээлттэй хилийн боомтоор нэвтрэн орох, гарах, эсхүл дамжин өнгөрөх бөгөөд тухайн Хэлэлцэн тохиролцогч Талын шилжилт хөдөлгөөний тухай хууль тогтоомжийн дагуу бүх шаардлагатай журмыг мөрдөнө.

5 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрээр Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын хүчин төгөлдөр дипломат болон албан паспорт эзэмшигч иргэд Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зорчих хугацаандаа тухайн улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүргээс чөлөөлөгдөхгүй.

6 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын тааламжгүй гэж үзсэн дипломат болон албан паспорт эзэмшигч иргэнийг өөрийн нутаг дэвсгэрт нэвтрэх, эсхүл зорчих хугацааг багасгах, эсхүл цуцлах Хэлэлцэн тохиролцогч Талын эрх бүхий байгууллагын эрхийг хөндөхгүй.

7 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч Тал бүр үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журам, эсхүл олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн зогсоох эрхтэй. Ийм

арга хэмжээ авах болон эргүүлэн цуцлах тухайгаа Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа дипломат шугамаар урьдчилан мэдэгдэнэ.

8 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохиролцогч Талууд энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дотор дипломат болон албан паспортын загварыг дипломат шугамаар солилцоно.

2. Хэлэлцэн тохиролцогч аль нэг Тал шинэ дипломат болон албан паспорт нэвтрүүлэх, эсхүл өөрийн ашиглаж буй дипломат болон албан паспортод өөрчлөлт оруулах тохиолдолд тэрхүү шинэ, эсхүл өөрчлөлт оруулсан дипломат болон албан паспортын загварыг шинэ паспорт нэвтрүүлэх болон паспортод өөрчлөлт оруулахаас доод Тал нь гуч (30) хоногийн өмнө эдгээр паспортын загварыг дипломат шугамаар Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа хүргүүлнэ.

9 дүгээр зүйл

Хэлэлцэн тохиролцогч Талууд энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх, эсхүл тайлбарлахтай холбогдуулан үүссэн аливаа маргааныг дипломат шугамаар зөвшилцөх замаар эв зүйгээр шийдвэрлэнэ.

10 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч Талууд бичгээр харилцан тохиролцож энэхүү хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Аливаа тийм нэмэлт, өөрчлөлт нь энэхүү хэлэлцээрийн нэг хэсэг болох бөгөөд энэхүү хэлэлцээрийн 11 дүгээр зүйлд дурдсан журмын дагуу хүчин төгөлдөр болно.

11 дүгээр зүйл

1. Энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч Талууд түүнийг хүчин төгөлдөр болгох Талаар дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа дипломат шугамаар харилцан мэдэгдсэн сүүлчийн бичгэн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү хэлэлцээрийг хугацаагүйгээр байгуулах бөгөөд Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын дипломат шугамаар зургаан (6) сарын өмнө Хэлэлцээрийг цуцлах тухай мэдэгдлийн дагуу хэлэлцээр цуцлагдана.

Улаанбаатар хотноо оны 7 дугаар сарын 14-ны өдөр монгол, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ



БҮГД НАЙРАМДАХ МАЛЬТА
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ





**AGREEMENT
BETWEEN
THE GOVERNMENT OF MONGOLIA
AND
THE GOVERNMENT OF THE REPUBLIC OF MALTA
ON THE EXEMPTION OF VISA REQUIREMENTS
FOR HOLDERS OF DIPLOMATIC AND OFFICIAL PASSPORTS**

The Government of Mongolia and the Government of the Republic of Malta, hereinafter referred to as the "Contracting Parties";

Being guided by the desire to develop further friendly relations between the two States;

Desiring to promote, facilitate and encourage exchange of visits of officials of the Contracting Parties by the exemption of visa requirements for holders of their valid diplomatic and official passports;

Have agreed as follows:

Article 1

Nationals of either Contracting Party holding valid diplomatic or official passports shall be exempted from visa requirements for entry into, stay in, exit from or transit through the territory of the other Contracting Party as the case may be for a period of time not exceeding thirty (30) days from the date of their entry.

Article 2

Nationals of either Contracting Party holding valid diplomatic or official passports, who wish to stay more than thirty (30) days in the territory of the other Contracting Party, shall obtain a visa in advance.

Article 3

This Agreement shall not exempt nationals of either Contracting Party who hold valid diplomatic or official passports and are appointed to diplomatic missions, consular posts or representative missions of international organisations in the territory of the other Contracting Party, as well as their family members who hold valid diplomatic or official passports, from the requirement to obtain visa for accreditation by the receiving State prior to their arrival.

Article 4

Nationals of either Contracting Party holding valid diplomatic or official passports shall enter into, exit from or transit through designated ports open to international travellers of the other Contracting Party and follow all necessary formalities in accordance with the immigration laws and regulations of that Contracting Party.

Article 5

This Agreement does not release nationals of either Contracting Party holding valid diplomatic and official passports from the obligation to observe the laws and regulations in force in the territory of the other Contracting Party during their stay in territory of that Contracting Party.

Article 6

This Agreement does not restrict the right of the competent authorities of either Contracting Party to prohibit diplomatic and official passport holders of the other Contracting Party who are considered undesirable from entering into or shorten or terminate their stay in its territory.

Article 7

Each Contracting Party may, for reason of ensuring national security, public order or public health, suspend this Agreement, either in whole or in part. The introduction and termination of such suspension shall be promptly notified in advance to the other Contracting Party through diplomatic channels.

Article 8

The Contracting Parties shall exchange through diplomatic channels, not later than thirty (30) days from the date of signing of this Agreement, the specimens of their diplomatic and official passports.

The Contracting Parties shall inform each other of the introduction of new diplomatic or official passports or modification to existing diplomatic or

official passports, and shall transmit through diplomatic channels specimens of the new or modified diplomatic or official passports at least thirty (30) days prior to their introduction or validity of any modification.

Article 9

Any dispute arising out of the implementation or application of this Agreement shall be settled by negotiation and consultation between the Contracting Parties.

Article 10

This Agreement may be amended in writing by mutual consent of the Contracting Parties. Any such amendment, which shall form an integral part of this Agreement, shall come into effect in accordance with the procedures set forth in Article 11.


Article 11

This Agreement shall enter into force thirty (30) days from the date of receipt of the latter written notification by which the Contracting Parties notify each other, through diplomatic channels, of the completion of their internal legal procedures required for the entry into force of this Agreement.

This Agreement shall remain in force for an indefinite period of time unless it is terminated by either Contracting Party upon a six (6) month prior written notice given to the other Contracting Party through diplomatic channels.

Signed in Ulaanbaatar on 14th of July in two originals, in Mongolian and English languages, both texts being equally authentic. In case of divergences, the English text shall prevail.

FOR THE GOVERNMENT
OF MONGOLIA



FOR THE GOVERNMENT
OF THE REPUBLIC OF MALTA

